



**НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Жанжин Д. Сүхбаатарын талбай 7, 1 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0035
Утас/Факс: (976-11) 32-71-99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА Т.НЯМ-ОЧИР
ТАНАА

2022. 11. 25 № 03/6219
танай _____ -ны № _____ -т

Хамтран ажиллах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.12 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 74 дүгээр зүйлийн 74.1 дэх хэсгийн үндэслэн Нийслэлийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр гаргасан “Цаг агаарын хүндрэлээс үүдэн гарах эрсдэлийг бууруулах, замын хөдөлгөөний түгжрэл, саатлыг зохицуулах зорилгоор авах зарим арга хэмжээний тухай” А/1496 дугаартай захирамжийн хэрэгжилтийг нийслэлийн хэмжээнд ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад хангуулан ажиллаж байна.

Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийг 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр цахимаар хичээллүүлэх арга хэмжээ авч, хамтран ажиллана уу.

Хувийг: Боловсрол, шинжлэх ухааны яаманд.

Хавсралт  хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



И.БААТАРХҮҮ

111020004253



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/1496

Улаанбаатар хот

Цаг агаарын хүндрэлээс үүдэн гарах эрсдэлийг бууруулах, замын хөдөлгөөний түгжрэл, саатлыг зохицуулах зорилгоор авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.12 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 74 дүгээр зүйлийн 74.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.11 дэх заалт, 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.2.2 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.4.2 дахь заалт, 9.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цаг агаарын хүндрэлээс үүдэн гарах эрсдэлийг бууруулах зорилгоор 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр нийслэлийн хэмжээнд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг доорх байгууллага, албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

1.1.төрийн болон төрийн бус өмчийн бүх шатны сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг цахимаар хичээллүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Нийслэлийн Боловсролын газар (Б.Амартүвшин)-т;

1.2.эмнэлэг, цагдаа, онцгой байдал, инженер хангамж, дэд бүтцийн чиглэлээр байнгын бэлэн байдлыг ханган ажилладагаас бусад нийслэл, дүүргийн бүх шатны байгууллагын ажилтан, албан хаагчдын 60-аас доошгүй хувийг болон жирэмсэн эмэгтэй, 10 хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцгийг гэрээс нь цахимаар ажиллуулахыг нийслэл, дүүргийн төрийн захиргааны болон харъяа байгууллагын удирдлагуудад;

1.3.замын хөдөлгөөний түгжрэл, саатлыг зохицуулах зорилгоор зорчилт хөдөлгөөний ачаалал ихтэй гудамж, замын уулзварт тээврийн хэрэгслийн хөдөлгөөний урсгал, чиглэлийг түр өөрчлөх, хязгаарлах, хаах, чиглэлийн тээврийн хэрэгсэл, тусгай дуут болон гэрлэн дохио бүхий тээврийн хэрэгслүүдийг үндсэн чиглэл, маршрутын дагуу зорчилт хийхийг дэмжих зохион байгуулалтын арга хэмжээ авч, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газар (Ц.Ариунболд), “Замын хөдөлгөөний удирдлагын төв” ОНӨТҮГ (С.Адъяасүрэн)-т тус тус;

1.4.замын хөдөлгөөний урсгал, чиглэлийг түр өөрчлөх, хязгаарлах үеэр болон хаасан гудамж, замуудад нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар (Р.Отгонжаргал)-т,

111020006855

зам, талбайн цэвэрлэгээ, үйлчилгээг хариуцаж, бэлэн байдлыг хангаж ажиллахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба (Д.Ганболд), "Нийслэлийн Хот тохижилтын газар" ОНӨААТҮГ (Б.Мөнхцэцэг)-т болон дүүргүүдийн Засаг дарга нарт;

1.5.замын хөдөлгөөний цогц үйл ажиллагааны цаг үеийн зохион байгуулалтыг удирдаж ажиллахыг Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газар (Ц.Ариунболд), "Замын хөдөлгөөний удирдлагын төв" ОНӨТҮГ (С.Адъяасүрэн)-т тус тус;

1.6.цаг агаарын хүндрэлээс үүдэн гарах эрсдэлийг бууруулах зорилгоор авах арга хэмжээний талаар иргэдэд мэдээлж, сурталчлахыг Нийслэлийн Сургалт, судалгаа, олон нийттэй харилцах газар (Г.Хонгорзул)-т.

2.Байгууллагын үйл ажиллагааны хэвийн байдлыг алдагдуулахгүйгээр ажилтан, албан хаагчдын 50-аас доошгүй хувийг болон жирэмсэн эмэгтэй, 12 хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцгийг гэрээс нь цахимаар ажиллуулахыг нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа бүх төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагын удирдлагуудад зөвлөсүгэй.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (И.Баатархүү)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА,
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Д.СУМЪЯАБАЗАР